



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮР
НӨЛӨӨТЭЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА**

**2022 оны 11
дүгээр сар**

**АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН 2023 ОНЫ
ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ АУДИТ**

2022 он

АГУУЛГА

АГУУЛГА	2
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ 1. АЙМГИЙН 2023 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ӨНДӨР ТӨЛӨВЛӨСӨН НЬ БИЕЛЭГДЭХГҮЙ БАЙХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА	7
1.1.Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн татварын бус орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.	7
1.2. Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 1504.0 сая төгрөгөөр тасрах төлөвтэй байна.....	8
1.3 Аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг өндөр төлөвлөсөн нь биелэгдэхгүй байх эрсдэлтэй байна	8
1.4. Сумуудын 2023 оны төсвийн орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа орон нутгийн суурь орлогыг нэмэгдүүлэх боломжуудыг бүрэн тооцоолоогүй байна	11
БҮЛЭГ 2. АЙМГИЙН 2023 ОНЫ ОРОН НУТГИЙН СУУРЬ ЗАРЛАГЫГ 2,716.4 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЖ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА	13
2.1 Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл хүлээгдэж буй гүйцэтгэлээр 182.7 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарах тооцоотой байна	13
2.2. Аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн суурь зарлагыг Сангийн яамнаас хянаж ирүүлсэн дүнгээс 2,716.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.	15
2.3. Аймгийн ИТХ-аас баталсан орон тооны хязгаарыг хэтрүүлэн ажиллуулсан байна	18
2.5. Он дамжсан өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ аваагүй, өр төлбөр нэмэгдэх эрсдэлтэй байна.....	23
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГЫГ ХАНГАХГҮЙ БАЙНА	26
3.1. Аймгийн 2022 оны Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар:	26
3.2. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт хуульд заасан шаардлагыг хангахгүй байна	28
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:	31
ЗӨВЛӨМЖ:	32
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	33

Товчилсон үгийн тайлбар

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ЕБС	Ерөнхий боловсрол сургууль
ХЦ	Хүүхдийн цэцэрлэг
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ХДТ	Хөгжимт драмын театр
ОНРТ	Орон нутгийн радио телевиз
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БТСГ	Биеийн тамир спортын газар
ХТА	Хот тохижуулах алба
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1	2022 оны төлөвлөгөө, 10 дугаар сарын гүйцэтгэл	12
Хүснэгт 2	Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл	14
Хүснэгт 3	2022 оны орон нутгийн төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл	
Хүснэгт 4	Аймгийн 2023 оны төсвийн орлогын төлөвлөлт	
Хүснэгт 5	Аймгийн төсөвт орох орон нутгийн орлогын төлөвлөлт	
Хүснэгт 6	Авлагын судалгаа	
Хүснэгт 7	Өглөгийн судалгаа	
Хүснэгт 8	Төсөвт байгууллагуудын өглөгийн нэр төрлөөрх судалгаа	
Хүснэгт 9	Тогтмол зардлын харьцуулсан судалгаа	
Хүснэгт 10	Байр ашиглалттай холбоотой зардлын төсвийг байгууллагаар нь харуулсан судалгаа	
Хүснэгт 11	Шүүхийн шийдвэрээр 2023 оны төсвийн төсөлд тусгасан халаалтын өглөгийг судалгаа	
Хүснэгт 12	Зарим төсөвт байгууллагуудын халаалтын өр төлбөрийн судалгаа	
Хүснэгт 13	Сангийн яамнаас хянаж ирүүлсэн 2023 оны төсвийн төсөөлөлтэй харьцуулсан судалгаа	

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан аудитын сэдэв, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг үндэслэн хийв.

Аудитын зорилт

Баян-Өлгий аймгийн “Орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудит” дүгнэлт гаргах гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Аймгийн 2023 оны суурь орлогын төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх санал, зөвлөмж бэлтгэж, дүгнэлт гаргах,
- Аймгийн 2023 оны төсвийн зарлагыг бууруулах, Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал зөвлөмж бэлтгэж, дүгнэлт гаргах

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Татварын хэлтэс, аймаг дахь Монгол банкны салбар, сумуудын ЗДТГ-ын Санхүүгийн алба болон бусад холбогдох байгууллагуудын 2023 оны төсвийн төлөвлөлт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулна.

“Орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудит” гүйцэтгэлийн аудитад аймгийн 2021-2022 оны төсвийн гүйцэтгэл, 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, Сангийн яаманд хүргүүлсэн болон Сангийн яамнаас хянаж ирүүлсэн аймгийн 2023 оны төсвийн төсөл, аймгийн Засаг даргаас аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн төсөл, холбогдох бусад үйл ажиллагааг хамруулна.

Аудитын хязгаарлалт

Байхгүй

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-1:2020 “Төрийн аудит.Тулгуур зарчим”, MNS 6817-2:2020 “Төрийн аудит.Ёс зүйн дүрэм”, MNS 6817-3:2020 “Төрийн аудит.Чанарын хяналт”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын тулгуур зарчим”, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

заавар, аргачлал”, “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан гүйцэтгэнэ.

Аудитаар аймгийн 2023 оны орлого, зарлагын төсвийн төсөл, үр дүнд дүн шинжилгээ, харьцуулалт хийх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах зэрэг арга зүйг ашиглан аудитын горимыг хэрэгжүүлж ажиллана.

Аудитын асуудлын шинжилгээ, аудитын загварын матрицын дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулна.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Айнур, Д.Назгүл, аудитор Б.Үүрийнтуяа, Ж.Назгүл, Х.Еркебулан, гэрээт аудитор К.Еркегүл нар хамтран гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл

Аудитын төлөвлөгөөг 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн дотор батлуулж, талбарын ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг нэгтгэн боловсруулж, дарга, тэргүүлэх аудиторт 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулж баталгаажуулна. Аймгийн 2023 оны төсвийн төсөлд гаргасан аудитын дүгнэлт, тайланг 12 дугаар сарын 02-ны дотор аймгийн ИТХ-д хүргүүлнэ.

2023 оны төсвийн төсөөлөл хугацаандаа ирүүлээгүйгээс аудитын баг төсвийн төсөлд өгөх дүгнэлт хязгаарлагдах

БҮЛЭГ 1. АЙМГИЙН 2023 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ӨНДӨР ТӨЛӨВЛӨСӨН НЬ БИЕЛЭГДЭХГҮЙ БАЙХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА

1.1.Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн татварын бус орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөө 15,931.2 сая төгрөг байна.

Хүснэгт №1 2022 оны төлөвлөгөө, 10 дугаар сарын гүйцэтгэл

Орлогын нэр төрөл	2022 оны төлөвлөгөө
Нийт орлого ба тусламжийн дүн	15,757,214.0
Татварын орлого	13,622,641.2
Татварын бус орлого	2,134,572.8

Эх сурвалж: Санхүү, Төрийн сангийн хэлтэс

Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөө 10 дугаар сарын байдлаар 11,949.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

2022 оны орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөг 10 дугаар сарын байдлаар гүйцэтгэлтэй харьцуулж татварын нэр төрлөөр судалж үзэхэд: Үйл ажиллагааны орлого 29.8 хувийн гүйцэтгэлтэй буюу 709.2 сая, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 18.0 хувийн гүйцэтгэлтэй буюу 459.5 сая, бууны албан татвар 27.6 хувийн гүйцэтгэлтэй буюу 47.0 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлбөр 1.7 хувийн гүйцэтгэлтэй буюу 130.8 сая, газрын төлбөр 44.1 хувийн гүйцэтгэлтэй буюу 184.9 сая, ус, рашааны төлбөр 46.7 хувийн гүйцэтгэлтэй буюу 13.3 сая, татварын бус орлого 43.8 хувийн гүйцэтгэлтэй буюу 1,200.6 сая төгрөгөөр дутуу биелэгдсэн байна.

Дээрх байдал нь 2022 оны аймгийн орон нутгийн татварын зарим орлогын төлөвлөлт үндэслэл муутай, татварын бус орлогын төлөвлөгөө биелэгдэх боломжгүй хэмжээгээр баталсаныг харуулж байна.

Хүснэгт№2 Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл

Орлогын нэр төрөл	2022 оны төлөвлөгөө	10-р сарын гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэл хувиар
	1	2	2-1	2/1
НИЙТ	15,757,214.0	11,949,883.1	(3,807,330.9)	75.8
Нийт орлого ба тусламжийн дүн	15,757,214.0	11,949,883.1	(3,807,330.9)	75.8
Татварын орлого	13,622,641.2	11,015,923.1	(2,606,718.1)	80.9
Орлогын албан татвар	10,819,880.0	7,973,174.6	(2,846,705.4)	73.7
Хувь хиний орлогын албан татвар	11,109,880.0	8,790,430.8	(2,319,449.2)	79.1
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	8,304,880.0	7,441,701.8	(863,178.2)	89.6
Үйл ажиллагааны орлого	1,010,000.0	300,763.8	(709,236.2)	29.8
Херенгийн орлого	1,555,000.0	823,143.6	(731,856.4)	52.9
Херенге борлуулсны орлого	240,000.0	224,821.6	(15,178.4)	93.7
Хувь хиний орлогын албан татварын буцаан олголт	(850,000.0)	(917,784.6)	(67,784.6)	108.0
Хувь хиний орлогын албан татварын буцаан олголт	(850,000.0)	(917,784.6)	(67,784.6)	108.0
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	560,000.0	100,528.4	(459,471.6)	18.0
Үйл ажиллагааны орлого	560,000.0	100,528.4	(459,471.6)	18.0
Херенгийн албан татвар	985,000.4	727,333.7	(257,666.7)	73.8
Їл хөдлөх эд херенгийн албан татвар	420,000.0	222,556.3	(197,443.7)	53.0
Бууны албан татвар	65,000.4	17,963.0	(47,037.4)	27.6
Автотээврийн болон еөрөө явагч хэрэгслийн албан татвар	500,000.0	486,814.4	(13,185.6)	97.4

Бусад татвар, төлбөр, хураамж	1,817,760.8	2,315,414.8	497,654.0	127.4
Бусад нийтлэг төлбөр, хураамж	537,960.4	624,138.4	86,178.0	116.0
Улсын тэмдэгтийн хураамж	345,000.0	559,128.6	214,128.6	162.1
Тигээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	59,960.0	62,796.8	2,836.8	104.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	133,000.4	2,213.0	(130,787.4)	1.7
Газрын төлбөр	330,800.0	145,870.1	(184,929.9)	44.1
Газрын төлбөр	330,800.0	145,870.1	(184,929.9)	44.1
Байгалийн нөөц ашигласны төлбөр	949,000.4	1,545,406.3	596,405.9	162.8
Ойн нөөц ашигласны төлбөр	48,000.0	41,525.1	(6,474.9)	86.5
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	876,000.4	1,492,218.5	616,218.1	170.3
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	25,000.0	11,662.7	(13,337.3)	46.7
Ургамлын нөөц ашигласны төлбөр		648.3	648.3	
Татварын бус орлого	2,134,572.8	933,960.0	(1,200,612.8)	43.8
Нийтлэг татварын бус орлого	2,134,572.8	933,960.0	(1,200,612.8)	43.8
Торгуулийн орлого	742,700.4	567,682.0	(175,018.4)	76.4
Төсөвт байгууллагын еерийн орлого	72,412.2		(72,412.2)	-
Нэр заагдаагүй бусад орлого	869,460.2	366,278.0	(503,182.2)	42.1
	450,000.0		(450,000.0)	-

Эх сурвалж: аймгийн Татварын хэлтэс

1.2. Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 1504.0 сая төгрөгөөр тасрах төлөвтэй байна.

Аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн 2022 оны орон нутгийн суурь орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлээр 14,252.6 сая төгрөгийн орлого орж төлөвлөгөө 1,504.0 сая төгрөгөөр тасрах төлөвтэй байна.

Хүснэгт №3 2022 оны орон нутгийн төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл
/мянган төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	2022 оны төлөвлөгөө	2022 оны ХБГ	Зөрүү
Нийт орлого ба тусламжийн дүн	15,757,214.00	14,252,593.10	(1,504,620.90)
Татварын орлого	13,622,641.20	13,118,633.10	(504,008.10)
Татварын бус орлого	2,134,572.80	1,133,960.00	(1,000,612.80)

Эх сурвалж: аймгийн Татварын хэлтэс

Татварын орлого 504.0 сая, татварын бус орлого 1000.6 сая төгрөгөөр тасрах төлөвтэй байна.

Хүлээгдэж буй гүйцэтгэлээр татварын орлогоос цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 200.8 сая, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 20.0 сая, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 230.1 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 130.5 сая, ан амьтны нөөц ашигласны төлбөр 626.2 сая төгрөгөөр давж, үйл ажиллагааны орлого 557.0 сая, хөрөнгийн орлого 299.2 сая, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 410.0 сая, газрын төлбөр 110.8 сая төгрөгөөр тасрах тооцоотой байна.

1.3 Аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг өндөр төлөвлөсөн нь биелэгдэхгүй байх эрсдэлтэй байна

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д “аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх” гэж заасан боловч төсвийн

төслийг холбогдох тооцоо судалгаа, тайлбар, баримтуудыг хавсарган хугацаанд нь ирүүлээгүй. Энэ зөрчлийг жил бүр давтан гаргаж байгааг дурьдах нь зүйтэй.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “жилийн төсвийн хязгаар” гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг “ гэсний дагуу Сангийн яамнаас орлогын доод хязгаарыг баталж ирүүлдэг.

Сангийн яаманд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны орон нутгийн орлогын төсвийг 13,022.3 сая төгрөгөөр төлөвлөж хүргүүлснийг 14,449.2 сая төгрөг байхаар хянаж ирүүлсэн байна.

Сангийн яамны хянаж ирүүлсэн 2023 оны орон нутгийн орлогын төлөвлөгөө 2022 оны тодотгосон төлөвлөгөөнөөс 1,308.1 сая төгрөгөөр буурсан байна.

Татварын нэр төрлөөр авч үзвэл: Хүн амын орлогын албан татварыг 95.1 сая, хувь хүний орлогын албан татварын буцаан олголтыг 150.0 сая, хөрөнгийн татварыг 62.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 196.0 сая, бусад татвар, төлбөр хураамжийг 472.6 сая, байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамжийг 276.0 сая, татварын бус орлогыг 646.8 сая төгрөгөөр бууруулсан байна.

Нийт орлогын 89 хувийг татварын орлогоос, 11 хувийг татварын бус орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Сангийн яамнаас Аймгийн 2023 оны төсвийн төсөлд суурь орлогыг 17,165.6 сая төгрөг байхаар хянаж ирүүлсэн бөгөөд Аймгийн Засаг даргаас ирүүлсэн төсөлд орон нутгийн төсвийн орлогыг 2,716,4 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Хүснэгт №4 Аймгийн 2023 оны төсвийн орлогын төлөвлөлт

/мянган төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	Сангийн яамны баталсан хязгаар	Орон нутгийн 2023 оны орлогын төсөв	Нэмэгдүүлсэн дүн
Нийт орлого ба тусламжийн дүн	14,449,156.6	17,165,580.8	2,716,424.20
Татварын орлого	12,961,400.0	15,550,824.2	2,589,424.20
Татварын бус орлого	1,487,756.6	1,614,756.6	127,000.00

Эх сурвалж: Санхүү, Төрийн сангийн хэлтэс

Үүнд:Татварын орлогоос “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”-ыг 608.9 сая, улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 260.8 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 395.0 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 215.0 сая, ан амьтны нөөц ашигласны төлбөрийг 1,109.7 сая, төсөвт байгууллагуудыг өөрийн орлогыг 127.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д заасан аймаг, нийслэлийн төсөвт орох татварын орлогуудаас автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамжийн орлого болон 23.7-д заасан татварын бус орлогын төрлүүдээс 2,169.2 сая төгрөгийн орлогыг аймгийн төсөвт оруулахаар Сангийн яамнаас баталж ирүүлснийг

аймгаас 302.5 сая төгрөгөөр бууруулж 1,866.8 сая төгрөг оруулахаар төлөвлөсөн байна.

Аймгийн 2022 оны орон нутгийн суурь орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл 14,252.6 сая төгрөг ба зарим татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө биелэгдэх боломжгүй байна.

Сангийн яамнаас хянаж ирүүлсэн орон нутгийн орлогын төлөвлөгөөг 2,716.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн нь биелэгдэхгүй байх эрсдэлтэй байна.

Иймд зарим татварын болон татварын бус орлогын төсвийн төлөвлөгөөг дахин хянаж, шаардлагатай бол бууруулах, биелэгдэх боломжтой татварын болон татварын бус орлогыг нэмэгдүүлж төлөвлөх нь зүйтэй.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.1-д заасан улсын төсөвт орох аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 364.0 сая төгрөгийг аймгийн төсөвт оруулахаар төлөвлөсөн. Татварын бус орлогын нэр заагдаагүй орлогод 345.3 сая төгрөгийн орлого төлөвлөсөн.

Азийн Хөгжлийн банкнаас “Орон нутгийн хотуудын Нийтийн аж ахуйг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд авсан “Суат” ХХК ОНӨААН-ийн 2001 онд авсан 991.1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн төлбөр төлөгдөөгүй он удаан жил болсонтой холбоотой Сангийн яам тус аймагт олгох 2022 онд санхүүгийн дэмжлэгээс 360.0 сая төгрөгийг суутган төлүүлсэнийг аймгийн 2023 оны орон нутгийн орлогын төсөлд нэр заагдаагүй орлогоор “Суат” ХХК-иас төлүүлэхээр 345.3 сая төгрөг тусгаж төлөвлөсөн байна.

Энэ нь 2023 онд “Суат” ХХК-иас бүрэн төлөгдөх боломжгүй, тэр хэмжээгээр төсвийн орлого тасрах эрсдэлтэй байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д заасан аймгийн төсөвт орох татварын орлогыг бүрэн төлөвлөсөн байна.

Хүснэгт №5 Аймгийн төсөвт орох орон нутгийн орлогын төлөвлөлт

/мянган төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	Сангийн яамны баталсан хязгаар	Татварын хэлтсийн орлогын төлөвлөлт	Зөрүү
Нийт орлого ба тусламжийн дүн	2,169,256.40	1,866,756.60	(302,499.80)
Татварын орлого	981,500.00	1,139,000.00	157,500.00
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	364,000.00	364,000.00	-
Авто болон өөрөө явагч хэрэгслийн татвар	550,000.00	550,000.00	-
Улсын тэмдэгтийн хураамж	67,500.00	200,000.00	132,500.00
Ус ашигласны төлбөр	-	25,000.00	25,000.00
Татварын бус орлого	1,187,756.40	727,756.60	(459,999.80)
Төсөвт газрын өөрийн орлого	42413	169413.2	127,000.20
Хүү, торгуулийн орлого	800000	213000	587,000.00
Орон нутгийн өмчид үйлдвэрлийн газрын өөрийн орлого	345343.4	345343.4	-
Нэр заагдаагүй бусад орлого	45000	345344.4	300,344.40

Эх сурвалж: Санхүү, Төрийн сангийн хэлтэс

Аймгийн төсөвт орох татварын орлогоос авто болон өөрөө явагч хэрэгсэлийн татварт 550.0 сая төгрөг төлөвлөсөн байна.

Аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн мэдээгээр автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварын 2022 оны төлөвлөгөө хүлээгдэж буй гүйцэтгээр давж биелэх төлөвтэй ба энэ төрлийн татвараас нийтдээ 317.7 сая төгрөгийн авлагатай байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 60 дугаар тогтоолоор автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн татварын хэмжээг шинэчлэн баталсан байна. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварыг 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөх боломжтой байна.

1.4. Сумуудын 2023 оны төсвийн орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа орон нутгийн суурь орлогыг нэмэгдүүлэх боломжуудыг бүрэн тооцоолоогүй байна

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8, 23.9-д заасан сум, дүүргийн төсвийг бүрдүүлэх татварын болон татварын бус орлогуудаас сумын төсвийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Тус газраас өнгөрсөн онд аймгийн 2022 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргахдаа үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж эхэлснээс хойш буюу сүүлийн 10 жилд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувь хэмжээнд өөрчлөлт оруулаагүй байгаа талаар анхааруулсан байна.

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуульд 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр “0.6-1.0” гэснийг 0.6-2.0 хувь гэж дээд хязгаарыг нэмэгдүүлж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 61 дүгээр тогтоолоор үл хөдлөх хөрөнгийн албан татварын хэмжээг 1 хувиар тогтоож, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг тогтоосон хэмжээгээр авч орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга, Татварын хэлтэст үүрэг болгосон байна.

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуульд орсон өөрчлөлтийг хэрэгжүүлж аймаг, сумдын төвийн буюу А бүсэд байршилтай үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 0.5 пунктээр нэмэгдүүлж 1.5 хүртэл хувиар тогтоох нь зүйтэй байна. Үл хөдлөх хөрөнгийн албан татварын 2023 оны орлогын төлөвлөгөөг 112.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөх боломж байна.

Сумуудын төсөвт орох татварын орлогоос ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын 2022 оны төлөвлөгөө давж биелэгдэх боломжтой байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг “Монголд зочлох жил” болгон зарласан.

Монголд зочлох жил болгон зарласантай холбоотой 2023-2024 онуудад гадаадаас ирэх жуулчдын тоо өсөх хандлагатай ба энэ хүрээнд зохион байгуулах, төлөвлөж хэрэгжүүлэх ажлуудыг эрчимжүүлснээр ан, амьтны нөөц ашигласны төлбөрөөс орох орлогыг нэмэгдүүлэх боломж байна. Ан, амьтны нөөц ашигласны

төлбөрийн 2023 оны орлогын төлөвлөгөөг 240.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөх боломж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 11 дугаар сарын 13-ны өдөр баталсан Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг сумууд хэрэгжүүлж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар малын төрөл тус бүрээр татварын хэмжээг тогтоосон боловч сумуудад малын татварыг төвлөрүүлэх ажил хангалтгүй байгаагаас малын тоо толгойн татварын орлогын биелэлт хангалтгүй байна.

Сумууд 2023 оны малын тоо толгойн татварыг бүрэн төвлөрүүлж сумын ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломж байна.

Дүгнэлт:

1. Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 1,504.0 сая төгрөгөөр тасрах төлөвтэй байна.

2. Аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг өндөр төлөвлөсөн нь биелэгдэхгүй байх эрсдэлтэй байна.

3. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын өөрийн орлогоос 2023 онд 345.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн нь бүрэн төлөгдөх боломжгүй байна.

4. Сумуудын орон нутгийн суурь орлогыг нэмэгдүүлэх боломжуудыг бүрэн тооцоолоогүй байна.

Баян-Өлгий аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн суурь орлогын төсөлд дараах саналуудыг өгч байна. Үүнд:

1. Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татварын авлагатай, татварын хэмжээг нэмэгдүүлсэн, 2022 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр давж биелэх төлөвтэй, жил бүр автомашины тоо нэмэгдэж байгаа тул авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөх;
2. Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогын төлөвлөгөөг 112.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөх;
3. Ан амьтны нөөц ашигласны төлбөрөөс орох орлогыг 240.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөх;

Санал зөвлөмж:

1. Биелэгдэх боломжгүй татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг дахин хянаж, үндэслэлтэй төлөвлөх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. АЙМГИЙН 2023 ОНЫ ОРОН НУТГИЙН СУУРЬ ЗАРЛАГЫГ 2,716.4 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЖ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

2.1 Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл хүлээгдэж буй гүйцэтгэлээр 182.7 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарах тооцоотой байна

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 15-ны 93 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн төсвийн суурь зарлагыг 24,831.8 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсвийн зарлага 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийтдээ 24,649.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч нийт дүнгээр 182.7 сая төгрөгийн хэмнэлттэй гарах урьдчилсан тооцоо гарч байна.

Үүнээс аймгийн ЗДТГ 2,998.2 сая, аймгийн ИТХ 538.7 сая, Орон нутгийн олон нийтийн радио телевиз 252.8 сая, Байгаль орчны газар 742.4 сая, Асрамжийн газар 121.1 сая, Санхүүгийн хяналт, аудитын алба 126.3 сая, Насан туршийн боловсролын төв 39.6 сая, Орон нутгийн өмчийн газар 203.3 сая, Сум дундын ойн анги 70.4 сая, Сумуудын ЗДТГ-ууд 6,645.8 сая, ИТХ 1,020.7 сая төгрөгийг гүйцэтгэлтэй гарахаар байна.

2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг дэлгэрэнгүйгээр харуулав.

Хүснэгт №	2022 он		зөрүү /хэмнэлт, хэтрэлт/
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Аймгийн ИТХурал	541.2	538.7	-2.5
Аймгийн ЗДТГазар	3024.5	2998.2	-26.3
Хэвлэл мэдээллийн алба	242.1	252.8	10.7
Байгаль орчин аялал жуулчлалын газар	742.4	742.4	0
Асрамжийн газар	139.4	121.1	-18.3
Санхүүгийн хяналт, аудитын алба	125.6	126.3	-0.7
Насан туршийн боловсрол	40.0	39.5	-0.5
Орон нутгийн өмчийн газар	203.3	203.3	0
Сум дундын ойн анги	69.9	70.4	0.5
Алтай сумын ЗДТГазар	377.5	377.5	0
Алтанцөгц сумын ЗДТГазар	340.0	384.3	44.3
Баяннуур сумын ЗДТГазар	331.4	372.4	41.0
Бугат сумын ЗДТГазар	325.4	382.8	57.4
Булган сумын ЗДТГазар	391.9	404.8	12.9
Буянт сумын ЗДТГазар	401.5	382.5	-19.0
Дэлүүн сумын ЗДТГазар	534.4	549.4	15.0
Ногооннуур сумын ЗДТГазар	417.5	468.3	50.8
Сагсай сумын ЗДТГазар	357.8	369.7	11.9
Толбо сумын ЗДТГазар	371.2	366.4	-4.8
Улаанхус сумын ЗДТГазар	394.5	491.2	96.7
Цагааннуур тосгоны ЗАлба	164.0	164.0	0
Цэнгэл сумын ЗДТГазар	396.7	521.1	124.4
Өлгий сумын ЗДТГазар	591.3	917.9	326.6
Алтай сумын ИТХурал	52.3	52.3	0

Алтанцөгц сумын ИТХурал	53.2	58.2	5.0
Баяннуур сумын ИТХурал	61.2	73.1	11.9
Бугат сумын ИТХурал	59.7	59.7	0
Булган сумын ИТХурал	57.2	65.2	8.0
Буянт сумын ИТХурал	55.2	50.7	-4.5
Дэлүүн сумын ИТХурал	63.7	63.7	0
Ногооннуур сумын ИТХурал ар	73.9	91.9	18.0
Сагсай сумын ИТХурал	64.3	63.8	-0.5
Толбо сумын ИТХурал	61.3	59.5	-1.8
Улаанхус сумын ИТХурал	61.8	83.7	21.9
Цэнгэл сумын ИТХурал	59.2	108.4	49.2
Өлгий сумын ИТХурал	106.8	190.3	83.5
Соёлын байгууллагын тогтмол зардал	895.9	895.9	0
Ерөнхий боловсрол тогтмол зардал	5990.7	5990.7	0
МСҮТ-ийн тогтмол зардал	239.4	239.4	0
СӨБ-ийн тогтмол зардал	2393.9	2393.9	0
ЭМТ-ийн тогтмол зардал	430.9	430.9	0
Соёлын байгууллагын байр ашиглалтын зардал	106.5	106.5	0
Хот тохижилт	177.5	177.5	0
Их засвар	900.8	900.8	0
Халамжийн сан	160.0	160.0	0
ОНОТХаламжийн үйлчилгээ	39.8	39.8	0
Засаг дарга	644.8	644.8	0
Урьд оны үлдэгдэл	381.0	381.0	0
Замын сан	639.1	639.1	0
БТСГ-ын тогтмол зардал	295.3	295.3	0
ДҮН	24831.8	24649.1	(182.7)

Нийт төсвийн 96. хувь нь бараа үйлчилгээний зардал, 3.1 хувь нь урсгал шилжүүлэг байна.

Хүснэгт №

сая төгрөг

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,831.8	24,649.1
УРСГАЛ ЗАРДАЛ	11,353.4	12,268.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,353.4	6,844.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,430.0	6,844.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	825.1	859.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	565.7	531.9
Хангамж, бараа материалын зардал	421.0	536.1
Нормативт зардал	34.7	30.3
Эд хогшил, урсгал засварын зардал	110.1	152.9
Томилолт, зочны зардал	110.7	137.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	616.4	413.5
Бараа үйлчилгээний бусад зардал	1,484.3	2,009.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	755.4	753.3
ТОГТМОЛ ЗАРДАЛУУД	13,478.4	12,381.0

Бараа үйлчилгээний зардлын 7,703.3 сая төгрөгийг буюу 31.3 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 531.9 сая төгрөгийг буюу 2.2 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 536.1 сая төгрөгийг буюу 2.1 хувийг хангамж, бараа материалын зардал, 30.3 сая төгрөгийг буюу 0.1 хувийг норматив зардал, эд хогшил, 152.9 сая төгрөгийг буюу 0.6 хувийг урсгалын засварын зардал,

137.4 сая төгрөгийг буюу 0.5 хувийг томилолт, зочны зардал, 413.5 сая төгрөгийг буюу 1.6 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, 2009.4 сая төгрөгийг буюу 8.2 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 753.3 сая төгрөгийг буюу 3.1 хувийг урсгал шилжүүлэг, 12381.0 сая төгрөгийг буюу 50.3 хувийг тогтмол зардал тус тус эзэлж байна.

Дүгнэлт:

1. Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл хүлээгдэж буй гүйцэтгэлээр 182.7 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарах тооцоотой байна.

2.2. Аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн суурь зарлагыг Сангийн яамнаас хянаж ирүүлсэн дүнгээс 2,716.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Сангийн яамнаас Баян-Өлгий аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн нийт зарлагын төсвийг 32,730.3 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна. Үүнээс орон нутгийн суурь зарлагыг 24701.5 сая төгрөгөөр, ОНХС-ийн шилжүүлгийг 8028.7 сая төгрөгөөр хянасан байна.

Аймгийн Засаг даргаас боловсруулсан 2023 оны орон нутгийн төсвийн төсөлд нийт зарлагыг 35,446.7 сая төгрөгөөр тооцож, орон нутгийн суурь зарлагыг 27,417.9 сая төгрөгөөр, ОНХС-ийн шилжүүлгийг 8,028.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Орон нутгийн суурь зарлагыг хянаж ирүүлсэн дүнгээс нийтдээ 2,716.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт №13

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Сангийн яамны хянасан	2023 оны төсвийн төсөөлөл	Зөрүү
А	1	2	/2-1/
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,701.5	27,418.0	2,716.4
УРСГАЛ ЗАРДАЛ	23,350.4	25,695.7	2,345.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,402.7	24,744.6	2,342.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,198.1	8,351.6	1,153.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	899.8	1,048.9	149.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,538.8	9,724.6	185.8
Хангамж, бараа материалын зардал	620.1	620.1	-
Нормативт зардал	214.9	214.6	(0.3)
Эд хогшил, урсгал засварын зардал	233.2	235.2	2.0
Томилолт, зочны зардал	166.1	196.1	30.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,046.0	1,839.1	(206.9)
Бараа үйлчилгээний бусад зардал	1,485.8	2,514.5	1,028.7
ТАТААС	345.3	345.3	-
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	345.3	345.3	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	602.4	605.7	3.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,351.2	1,351.2	-

ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		371.1	371.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,701.5	27,418.0	2,716.4
Улсын төсвөөс санхүүжих	-	-	-
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих			-
Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,659.1	27,248.6	2,589.4
Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,659.1	27,248.6	2,589.4
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			-
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-	-
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих			-
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	42.4	169.4	127.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42.4	169.4	127.0
Урьд оны үлдэгдлээс	-	-	-

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

Орон нутгийн 2023 оны төсвийн зарлагын бүтцийг авч үзвэл нийт зарлагын 93.7 хувийг урсгал зардал, 4.9 хувийг хөрөнгө оруулалтын зардал, 1.4 хувийг эргэж төлөгдөх зээл эзэлж байна. Урсгал зардлын 96.3 хувийг бараа үйлчилгээний зардал, 1.4 хувийг татаас санхүүжилт, 2.36 хувийг урсгал шилжүүлэг эзэлж байна.

Төсвийн төсөлд дараах зардлуудыг нэмэгдүүлж тооцсон байна. Үүнд:

Бараа, ажил үйлчилгээний зардлыг 2,342.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсний дотор цалин хөлс, урамшуулалт цалингийн зардлыг 1,153.5 сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 149.2 сая төгрөгөөр, байр ашиглалтын зардлыг 185.8 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 30.0 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,028.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын төсвөөс 206.9 сая төгрөгийг бууруулж, бараа үйлчилгээний бусад зардалд шилжүүлсэн байна.

Сумдын ЗДТГ-ын төсвийг 778.3 сая төгрөгөөр, ЕБС-ийн тогтмол болон байр үйлчилгээний зардлыг 243.3 сая төгрөгөөр, СӨБ-ийн тогтмол болон байр үйлчилгээний зардлыг 197,1 сая төгрөгөөр, аймгийн ЗДТГ-ын төсвийг 1,669.6 сая төгрөгөөр, аймгийн ИТХ-ын төсвийг 31,6 сая төгрөгөөр, Асрамжийн газрын төсвийг 25.8 сая төгрөгөөр, Сум дундын ойн ангийн төсвийг 1.8 сая төгрөгөөр, Засаг даргын ерөнхий данс зардлыг 755.2 сая төгрөгөөр, Орон нутгийн өмчийн газрын төсвийг 52.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, сумдын ИТХ-ын төсвийг 43.9 сая төгрөгөөр, Соёлын байгууллагуудын тогтмол зардлыг 251.9 сая төгрөгөөр, Эрүүл мэндийн байгууллагын тогтмол болон байр үйлчилгээний зардлыг 49.1 сая төгрөгөөр, Олон нийтийн радио телевизийн төсвийг 27.3 сая төгрөгөөр, Байгаль орчны газрын төсвийг 318.2 сая төгрөгөөр, Санхүүгийн хяналт аудитын албаны төсвийг 2.5 сая төгрөгөөр тус тус бууруулан төлөвлөсөн байна.

Хөрөнгийн зардалд нийтдээ 1,351.2 сая төгрөг төлөвлөгдөж, орон нутгийн өмчит “Суат” ХХК-ны урт хугацаат зээлийн хүүгийн өглөгт төлөх 345.3 сая төгрөгийг татаас шилжүүлгийн зардалд, үндсэн зээлээс төлөгдөх 371.1 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд төлөвлөсөн байна.

Төсвийн төсөлд нийт дүнгээр нэмэгдүүлсэн зардлуудыг судалж үзэхэд:

1. Цалингийн зардлыг 1,153.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь төрийн захиргааны албан хаагчдын цалин, нэмэгдэл нэмэгдсэн, төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн нэмэгдсэн, аймгийн ЗДТГ-ын орон тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

Зарим төсөвт байгууллагуудын орон тоо хязгаараас илүү байгаа нь цалингийн зардал нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

2. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 185.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь байр түрээслэж буй 5 цэцэрлэгийн түрээсийн зардал, Соёлын газрын түрээсийн зардал, шинээр ашиглалтад орж байгаа 2 Соёлын төвийн тогтмол зардал, шинээр ашиглалтад орох Төрийн үйлчилгээний байгууллагын байрны тогтмол зардал орж тооцогдсон дүнтэй байна. Мөн холбогдох хуулийн дагуу аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний газрын дарга нарын байрны түрээсийн зардал орж тооцогдсон байна.

3. Аймгийн ЗДТГ-т гаднаас ирсэн зочдыг хүлээн авах зардалд 30.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь томилолт, зочны зардлыг 30.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

4. Бараа үйлчилгээний бусад зардлыг 1028.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь аймгийн Засаг даргын ерөнхий дансны төсөвт мэдээлэл технологийн зардалд 735.2 сая төгрөгийг, аймгийн ЗДТГ-т бараа үйлчилгээний бусад зардалд 293.5 сая төгрөгийг нэмэгдүүлж төлөвлөсөнтэй холбоотой байна.

5. Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр 345.3 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх зээл 371.1 сая төгрөгөөр төсөвт тусгасан нь Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5-д “Орон нутгийн төсөвт Өрийн удирдлагын тухай хууль болон энэ хуулийн 41.5, 57.4, 62.2-т зааснаас бусад тохиолдолд өр үүсгэх, баталгаа гаргахыг хориглоно” гэсэн заалтад нийцэхгүй байна.

Аймгийн 2023 оны төсвийн зарлагын төслөөс дараах зардлуудыг бууруулах боломжтой гэж үзлээ. Үүнд:

1. Аймгаас сумдад байгаль орчныг нөхөн сэргээх зардлыг 1,061.4 сая төгрөгөөр тооцож сумдын ЗДТГ-ын төсөвт тусгасан нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно” гэсний үндэслэж, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөний 15-85 хувиар тооцсон байна. Энэхүү тооцоог нягталж үзэхэд түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс 15 хувиар тооцохоор заасныг нэмэгдүүлж 35 хувиар тооцож төсөвт тусгасан. Иймд илүү тооцсон 20 хувийн татварын 90.0 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаас бууруулах.

2. Сумын ИТХ-ын шатахууны зардлыг 25.0 сая төгрөгөөр бууруулах.

Дүгнэлт:

1. Аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн суурь зарлагыг Сангийн яамнаас хянаж ирүүлсэн дүнгээс 2,716.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Санал зөвлөмж:

1. “Суат” ХХК-ны урт хугацаат зээлийн төлбөр болон хүүгийн төлбөрт орон нутгийн төсвөөс төлөх зардлыг бүрэн төлүүлж орон нутгийн төсөвт оруулах.

2.3. Аймгийн ИТХ-аас баталсан орон тооны хязгаарыг хэтрүүлэн ажиллуулсан байна

Орон тоо, цалингийн зардлын төсвийн төслийн талаар:

Сангийн яам тус аймгийн 2023 оны цалингийн зардлын төсвийг 7,198.0 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.

Аймгийн Засаг даргаас боловсруулсан төсөлд цалингийн зардлыг 8,351.5 сая төгрөгөөр төлөвлөж 1,153.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Цалингийн зардал нэмэгдсэнтэй холбоотой НДШ-ийн зардал дагаж нэмэгдсэн байна.

Энэ нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалин нэг шатлалд шилжсэн, үндсэн цалинг 20 хувиар нэмэгдүүлсэн, орон нутгийн нэмэгдэл 10 хувиар нэмэгдсэн, төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин 6 хувиар нэмэгдсэн, Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбоотой 8 байцаагчийн орон тоо чиг үүргийн дагуу аймгийн ЗДТГ-т шилжиж байгаатай холбоотой байна.

Сангийн яам 2023 оны төсөвт орон тооны хязгаарыг 479 хүнээр хянаж ирүүлсэн бай төсвийн төсөлд байгууллага бүрээр хуваарилсан орон тоо 639 байгаа нь 160 орон тоогоор илүү байна.

Үүнд: Аймгийн Засаг даргын тамгын газарт 38, сумуудын ЗДТГ-т 101, аймгийн ИТХ-д 3, Орон нутгийн өмчийн газарт 5, Сум дундын ойн ангид 4, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 5, Асрамжийн газарт 4, нийт 160 орон тооны цалингийн зардлыг 2023 оны төсвийн төсөлд нэмж тусгажээ. Орон нутгийн олон нийтийн радио телевизийн орон тоо, цалингийн зардлыг өөрийн орлогоор санхүүжүүлэхээр тусгасан байна.

Аймгийн ИТХ-аас баталсан 2022 оны төсөвт орон нутгийн төсөвт байгууллагуудын орон тооны хязгаарыг 614 хүнээр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 660 хүн ажиллаж байна. Энэ нь 2023 оны төсөвт тусгасан орон тооноос 135 хүнээр илүү байна. Аймгийн ИТХ-аас баталсан орон тооны хязгаараас 6 байгууллагад 13 орон тоо дутуу, 18 байгууллагад 61 орон тоо илүү байна.

Тухайлбал: Бугат сумын ЗДТГ-т 1, Булган сумын ЗДТГ-т 3, Дэлүүн сумын ЗДТГ-т 5, Ногооннуур сумын ЗДТГ-т 9, Сагсай сумын ЗДТГ-т 1, Улаанхус сумын ЗДТГ-т 4, Өлгий сумын ЗДТГ-т 13, Цагааннуур тосгоны захирагчийн албанд 6, Булган сумын ИТХ-д 1, Дэлүүн сумын ИТХ-д 1, Ногооннуур сумын ИТХ-д 1, Цэнгэл сумын ИТХ-д 1, Өлгий сумын ИТХ-д 1, Санхүүгийн хяналт, аудитын албад 1, Сум

дундын ойн анги 4, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 5, Насан туршийн боловсролын төвд 2 орон тоо илүү байна.

Үүнийг холбогдох байгууллагуудаас тодруулж үзэхэд Бугат сумын Засаг даргын туслах, Булган сумын ЗДТГ-т сахиул, олон нийтийн цагдаа, биеийн тамирын зааварлагч, Дэлүүн сумын ЗДТГ-т хэвлэл мэдээллийн ажилтан, олон нийтийн цагдаа, цахилгаанчин, хогийн сахиул, Ногооннуур сумын ЗДТГ-т ажлын албаны дарга, биеийн тамирын арга зүйч, улаан загалмайн үйл ажиллагаа хариуцсан ажилтан, галч, олон нийтийн цагдаа, сум тохижуулах албаны дарга, зам цэвэрлэх ажилтан 2, ОНХСан хариуцсан мэргэжилтэн, Сагсай сумын ЗДТГ-т хэвлэл мэдээллийн ажилтан, Улаанхус сумын ЗДТГ-т олон нийтийн цагдаа, байгаль орчны ажилтан 2, нэг цонхны үйлчлэгч, Өлгий сумын ЗДТГ-т нийтийн цагдаа 3, биеийн тамирын зааварлагч, багийн ажлын албаны дарга, мэдээлэл технологийн мэргэжилтэн, жижүүр, багийн нийгмийн ажилтан 3, аялал жуулчлал, спорт, эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн, багийн нарийн бичиг, багийн засаг даргын ажлын албаны дарга, Цагааннуур тосгоны захирагчийн албанд худаг хариуцсан гэрээт ажилтан 4, цагдаагийн кабоны цэвэрлэгч, татвар хураагч, Булган сумын ИТХ-д хурлын ажилтан, Дэлүүн сумын ИТХ-д иргэний танхимын зохицуулагч, Ногооннуур сумын ИТХ-д жолооч, Цэнгэл сумын ИТХ-д ажлын албаны мэргэжилтэн, Өлгий сумын ИТХ-д нягтлан бодогч, Санхүүгийн хяналт, аудитын албанд нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтан, Сум дундын ойн ангид нягтлан бодогч, жолооч, нярав, бичиг хэргийн ажилтан, манаач, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт жолооч, үйлчлэгч, манаач 3, Насан туршийн боловсролын төвд нягтлан бодогч, архив бичиг хэргийн ажилтан зэрэг онцын шаардлагагүй орон тоог авч ажиллуулсан байна.

Дүгнэлт:

1. Аймгийн ИТХ-аас баталсан орон тооны хязгаарыг хэтрүүлэн ажиллуулсан байна.

Зөвлөмж:

1. Аймгийн ИТХ-аас баталсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллах.
2. Орон нутгийн төсөвт байгууллагуудын орон тооны нягтралыг сайжруулж, шаардлагагүй орон тоог хасах замаар цалингийн зардлыг хэмнэх.

2.4. Байр ашиглалттай холбоотой зардлын төсвийн төслийн талаар:

Сангийн яамнаас аймгийн 2023 оны төсөвт байр ашиглалттай холбоотой зардлын нийт төсвийг 9,538.8 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.

Үүнд гэрэл цахилгааны зардлын төсвийг 601.2 сая төгрөг, түлш халаалтын зардлын төсвийг 8,628.4 сая төгрөг, цэвэр бохир усны зардлын төсвийг 309.2 сая төгрөг байхаар төлөвлөжээ.

Төсвийн төсөлд байр ашиглалттай холбоотой зардлыг нийт дүнгээр 185.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 9,724.6 сая төгрөг байхаар төлөвлөсөн байна.

Хүснэгт №9	/мянган төгрөгөөр/			
	Зардлын зүйл анги	Сангийн яамнаас хянаж ирүүлсэн төсөв	Аймгийн Засаг даргын төсвийн төсөл	Зөрүү

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,538,814.8	9,724,570.0	185,755.2
Гэрэл, цахилгаан	601,215.3	536,038.0	-65,177.3
Түлш, халаалт	8,628,358.5	8,891,930.9	263,572.4
Цэвэр, бохир ус	309,241.0	269,601.1	-39,639.9
Байрны түрээс	0	27,000.0	27,000.0

Гэрэл цахилгааны зардлыг 65.2 сая төгрөгөөр, цэвэр, бохир усны зардлыг 39.6 сая төгрөгөөр бууруулж, түлш халаалтын зардлыг 263.6 сая төгрөгөөр, байрны түрээсийг 27.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж тооцсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний газрын даргын байрны түрээсийн зардалд 12.0 сая төгрөгийн, Соёлын хэлтсийн түрээсийн зардалд 15.0 сая төгрөгийн төсвийг Санхүү, төрийн сангийн хэлтсээс нэмж төлөвлөжээ.

Байр ашиглалттай холбоотой зардлын төсвийг байгууллагаар нь харуулбал:

Хүснэгт №10

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Сангийн яамнаас ирүүлсэн төсөв	Аймгийн ИТХ-д оруулах санал	Зөрүү төсөв
1	Соёлын төвийн байгууллагууд	753,877.40	516,936.20	-236,941.20
2	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд	1,222,296.30	1,443,722.20	221,425.90
3	Ерөнхий боловсролын сургуулиуд	5,035,819.10	5,279,122.50	243,303.40
4	Эрүүл мэндийн төвүүд	482,080.70	430,047.80	-52,032.90
5	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	256,651.90	253,651.90	-3,000.00
6	Аймгийн Асрамжийн газар	9,490.70	9,490.70	0.00
7	Ахмадын хороо	25,177.10	25,177.10	0.00
8	Аймаг, сумдын ЗДТГазар	833,006.20	861,006.20	28,000.00
9	МҮОНРТ-ийн Баян-Өлгий дахь салбар	21,722.50	21,722.50	0.00
10	Хөгжимт драмын театр	413,649.60	413,649.60	0.00
11	Номын сан	45,635.10	45,635.10	0.00
12	Музей	77,666.70	77,666.70	0.00
13	Байгаль орчны газар	15,073.90	15,073.90	0.00
14	Биеийн тамир спортын газар	316,667.60	316,667.60	0.00
15	Соёлын газар	30,000.00	15,000.00	-15,000.00
	Байр ашиглалттай холбоотой зардлын дүн	9,538,814.80	9,724,570.00	185,755.20

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг аймаг, сумын Засаг даргын тамгын газруудад 28.0 сая, ерөнхий боловсролын сургуулиудад 243.3 сая, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад 221.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, соёлын байгууллагуудаас 236.9 сая, эрүүл мэндийн төвийн байгууллагуудаас 52.0 сая, Мэргэжлийн сургалтын үйлдвэрлэлийн төвөөс 3.0 сая, Соёлын хэлтсээс 15.0 сая төгрөгийн төсвийг бууруулсан байна.

Бууруулж төлөвлөсөн шалтгаан нь нэгдсэн халаалтад холбогдсон Соёлын төв, Хөгжимт драмын театр, Музей, Номын сангуудын халаалтын хугацааг 7 сараар тооцож, Хотгор эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа зогссон, МСҮТ-ийн байр ашиглалттай холбоотой зардлаас 3.0 сая төгрөгийг тус төвийн урсгал зардалд

шилжүүлж, Соёлын газрын байрны түрээсийн зардлыг 6 сараар тооцож бууруулж тусгасан байна.

Халаалтын зардлын төсвийн төслийг 2022 оны төсөвтэй харьцуулахад сумдын Засаг даргын тамгын газрын төсвийг 284.7 сая төгрөгөөр, Эрүүл мэндийн төсвийг 14.2 сая төгрөгөөр, Сургуулийн өмнөх боловсролын төсвийг 392.3 сая төгрөгөөр, Ерөнхий боловсролын төсвийг 840.3 сая төгрөгөөр, сумдын Соёлын төвийн төсвийг 126.6 сая төгрөгөөр, орон нутгийн байгууллагуудын төсвийг 124.6 сая төгрөгөөр нийтдээ 1,782.7 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Үүнээс шүүхийн шийдвэрээр 14 байгууллагын 1,104.7 сая төгрөгийн он дамжсан халаалтын өглөгийг барагдуулахаар төлөвлөсөн байна.

Өлгий сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн шинэ байр ашиглалтад орохтой холбоотой 29.0 сая, 2, 5 дугаар цэцэрлэгийн халаалтын зардлыг 8 сараар тооцож 18.9-24.0 сая, 11 дүгээр цэцэрлэгийн байрны түрээсийн зардалд 80.7 сая, 12 дугаар цэцэрлэгийн байрны түрээсийн зардалд 38.3 сая, 23 дугаар цэцэрлэгийн байрны түрээсийн зардалд 28.0 сая, Сагсай сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн байрны өргөтгөлд 38.1 сая, Цэнгэл сумын Руханият хувийн сургууль төрийн өмчийн сургууль болж байгаатай холбоотой 15.2 сая, Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн он дамжсан өглөгт 72.5 сая, Өлгий сумын 4 дүгээр сургуулийн он дамжсан өглөгт 63.7 сая төгрөгийг, нийтдээ 408.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөжээ.

Төрийн үйлчилгээний цогцолборын байрны халаалтын зардалд 147.9 сая, Толбо сумын сургуульд 54.0 сая, Цэнгэл сумын Тува бага сургуульд 37.3 сая, Цагааннуур тосгоны дунд сургуульд 36.0 сая буюу нийт 275.2 сая төгрөгийн төсвийг, энгийн халаалттай байгууллагуудын түлээ, нүүрсний үнийн зөрүүд 83.6 сая төгрөгийг нэмэгдүүлсэн байна.

Мөн Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгээс 2.3 сая, Ногооннуур сумын 1 дүгээр сургуулиас 35.8 сая, Бугат сумын сургуулиас 10.0 сая, Бугат сумын ЭМТ-өөс 8.4 сая, Сагсай сумын 2 дугаар цэцэрлэгээс 7.2 сая, сумдын Соёлын төвүүдээс 26.0 сая төгрөг нийтдээ 89.7 сая төгрөгөөр бууруулсан байна.

Шүүхийн шийдвэрээр төсвөөс нөхөн төлөхөөр 2023 оны төсвийн төсөлд тусгасан халаалтын өглөгийг байгууллага бүрээр хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №11

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Шүүхийн шийдвэрийн дүн
1	Баянуур сумын ЗДТГазар	31,274.3
2	Баяннуур сумын Эрүүл мэндийн төв	7,853.0
3	Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэг	33,010.6
4	Баяннуур сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	249,700.0
5	Баяннуур сумын Соёлын төв	57,048.8
6	Буянт сумын ЗДТГазар	36,830.7
7	Буянт сумын Эрүүл мэндийн төв	10,997.0
8	Буянт сумын Хүүхдийн цэцэрлэг	59,544.9
9	Буянт сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	209,534.0
10	Буянт сумын Соёлын төв	100,302.2
11	Улаанхус сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	87,006.0
12	Өлгийн сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	51,003.0

13	Өлгийн сумын ЕБ-ын 2 дугаар сургууль	100,971.7
14	Өлгийн сумын ЕБ-ын 3 дугаар сургууль	69,731.0
Нийт дүн		1,104,807.2

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 24.6 сая төгрөгийн халаалтын өрийг төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан боловч 2023 оны төсвийн төсөлд суулгаагүй байна.

Төсөвт байгууллагуудаас халаалтын зардлын 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн талаар судалгаа авахад аймгийн дүнгээр нийтдээ 1,964.5 сая төгрөгийн өртэй гарах урьдчилсан тооцоо гарч байгаа ба зарим байгууллагуудын халаалтын өглөгийг шүүхийн шийдвэрээр нэхэмжилснээс хойших байдлаар хүснэгтээр гаргав.

Хүснэгт №12

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	2022 оны жилийн эцсээр гарах өглөгийн дүн
1	Баяннуур сумын Эрүүл мэндийн төв	23,647.0
2	Дэлүүн сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	153,755.1
3	Улаанхус сумын ЕБ-ын 2 дугаар сургууль	24,600.0
4	Улаанхус сумын ЕБ-ын 3 дугаар сургууль	18,600.0
5	Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэг	22,000.0
6	Улаанхус сумын Согоог Хүүхдийн цэцэрлэг	17,700.0
7	Өлгий сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	87,497.0
8	Өлгий сумын ЕБ-ын 2 дугаар сургууль	150,028.3
9	Өлгий сумын ЕБ-ын 3 дугаар сургууль	81,400.0
10	Өлгий сумын ЕБ-ын 4 дүгээр сургууль	126,200.0
11	Өлгий сумын ЕБ-ын 6 дугаар сургууль	28,600.0
12	Аймгийн Музей	23,096.3
13	Биеийн тамир спортын газар	96,116.2
14	Хөгжимт драмын театр	141,613.0
15	Байгаль орчны газар	2,000.0
Нийт дүн		996,852.9

Төсөвт байгууллагууд халаалтын зардлын их хэмжээний өглөгтэй байгаа шалтгаан нь Санхүү төрийн сангийн хэлтсээс нэгдсэн халаалтад холбогдсон байгууллагуудын халаалтын төсвийг үндэслэлгүй хуваарилж, батлуулж ирсэнтэй холбоотой байна.

Мөн халаалтын төсвийг үндэслэлгүй хуваарилж, батлуулж ирсэнтэй холбоотой зарим байгууллагууд он дамжсан өр төлбөрийг барагдуулах талаар шүүхэд хандаж шүүхийн шийдвэрээр халаалтын зардлын зөрүүг төлүүлж байгаа нь төсөвт нэмэлт ачаалал үүсгэх эрсдэлтэй байгааг цаашид анхаарах хэрэгтэй байна.

Дүгнэлт:

1. Төсвийн төсөлд байр ашиглалттай холбоотой зардлыг нийт дүнгээр 185.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн.

2. Төсвийн төсөлд 14 байгууллагын 1,104.8 сая төгрөгийн халаалтын өглөгийг Шүүхийн шийдвэрээр төсвөөс нөхөн төлөхөөр тусгасан.

3. Халаалтын зардлын тооцоотой холбоотой 2022 оны оны эцэст 1,964.5 сая төгрөгийн өглөгтэй гарах урьдчилсан тооцоо гарч байна.

Санал зөвлөмж:

1. Толбо сумын сургуульд 54.0 сая, Цэнгэл сумын Тува бага сургуульд 37.3 сая, Цагааннуур тосгоны дунд сургуульд 36.0 сая, нийт 127.3 төгрөгийн халаалтын төсвийг үндэслэлгүй нэмэгдүүлснийг өртэй байгууллагуудын халаалтын зардалд шилжүүлэх.

2. Төсөвт байгууллагуудын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд тавих хяналтыг сайжруулж, батлагдсан төсөвт зардлыг хэмнэлттэй зарцуулах.

3. Нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглаж зардлыг хэмнэх.

2.5. Он дамжсан өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ аваагүй, өр төлбөр нэмэгдэх эрсдэлтэй байна

Төсөвт байгууллагын авлагын талаар:

Төсөвт байгууллагуудаас 2021 оны оны эцэст 87 байгууллага 891.6 сая төгрөгийн авлагатай байна.

Хүснэгт №6 Авлагын судалгаа:

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл /2021 оны жилийн эцэс/	Эцсийн үлдэгдэл /2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр /	Өсөлт (+), Бууралт (-)
Аймгийн ЗДТГ	4.3	-	(4.3)
Аймгийн ИТХурал	2.7	-	(2.7)
Асрамжийн газар	1.4	0.7	(0.7)
ГХБХБГазар	1.5	-	(1.5)
Өрхийн ЭМТөв	42.9	-	(42.9)
Ахмадын сан	6.5	6.5	-
ОНБ-ын авлагын дүн	59.3	7.2	(52.1)
Сумын ИТХ, ЗДТГ-уудын авлагын дүн	25.9	17.6	(8.3)
ТЗШ-ийн байгууллагуудын авлагын дүн	806.4	40.9	(765.5)
Аймгийн дүн	891.6	65.7	(825.9)
<i>Үүнээс, авлага нэр төрлөөр</i>			
Цалин хөлс холбоотой авлага	70.6	26.4	(44.2)
Бусад авлага	821.0	39.3	(781.7)
Дүн	891.6	65.7	(825.9)

Эх сурвалж: 2021 оны жилийн эцсийн авлагын судалгаа, төсөвт байгууллагуудаас авсан авлагын хүлээгдэж буй гүйцэтгэлийн судалгаа

Байгууллагуудаас авсан судалгаагаар оны эхний авлага 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 825.9 сая төгрөгөөр буурахаар байна. Үүний 92.7 хувь нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын, 1 хувь нь сумын ИТХ, ЗДТГ-ын, 6.3 хувь нь орон нутгийн төсөвт байгууллагуудын авлага байна.

Ерөнхийн боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүдэд үндсэн хөрөнгө худалдан авахтай холбоотой үүссэн авлагыг, сумдын ЭМТ-үүд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн авлагыг барагдуулж ажилласан байна.

Оны эхний авлагаас цалин хөлстэй холбоотой авлага 26.4 сая, бусад тооцооны авлага 781.7 сая төгрөгөөр буурчээ. Төсөвт байгууллагууд он дамжсан авлагыг барагдуулж, шинээр авлага үүсээгүй байна.

Төсөвт байгууллагын өр төлбөрийн талаар:

Хүснэгт №7 Өглөгийн судалгаа

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл /2021 оны жилийн эцэс/	Эцсийн үлдэгдэл /2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр /	Өсөлт (+), Бууралт (-)
ТЗШ-ийн байгууллагуудын дүн	873.4	1,880.0	1,006.6
Сумын ИТХ, ЗДТГ-уудын дүн	90.2	179.6	89.4
Хөгжимт драмын театр	92.2	141.6	49.4
Биеийн тамир, спортын газар	55.6	96.1	40.5
Аймгийн Музей	25.9	23.1	(2.8)
Асрамжийн газар	3.5	17.0	13.5
Орон нутгийн олон нийтийн радио, телевиз		7.7	7.7
Аймгийн Номын сан		3.4	3.4
Байгаль орчин аялал жуулчлалын		2.5	2.5
Хот тохижуулах алба	24.7	39.9	15.2
Хүүхэд гэр бүл хөгжлийн газар	0.1	-	(0.1)
Ахмадын сан	5.7	10.7	5.0
Өрхийн ЭМТөв	52.8	-	(52.8)
Орон нутгийн төсөвт байгууллагуудын дүн	260.5	342.0	81.5
НИЙТ ӨГЛӨГИЙН ДҮН	1,224.1	2,401.6	1,177.5
<i>Үүнээс. өглөг нэр төрлөөр</i>			
Цалин хөлс холбоотой өглөг	215.2	192.8	(22.4)
Бусад зардлын өглөг	296.6	244.3	(52.3)
Түлш халаалтын өглөг	712.3	1,964.5	1,252.2
НИЙТ ДҮН	1,224.1	2,401.6	1,177.5

Эх сурвалж: 2021 оны жилийн эцсийн өглөгийн судалгаа, төсөвт байгууллагуудаас авсан өглөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн судалгаа

Төсөвт байгууллагууд 2021 оны эцэст нийтдээ 1224.1 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна. Байгууллагуудаас авсан судалгаагаар 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2,401.6 сая төгрөгийн өглөгтэй гарч, оны эхнээс 1,177.5 сая төгрөгөөр нэмэгдэх эрсдэл үүсгэхээр байна.

Энэхүү өглөгийн 192.8 сая төгрөг нь цалин хөлстэй холбоотой, 244.3 сая төгрөг нь бусад зардлын /гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, бусад бараа үйлчилгээний/, 1,964.5 сая төгрөг нь түлш халаалтыг зардлын өглөг байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын өглөг 1,006.6 сая, сумын ИТХ, ЗДТГ-уудын өглөг 89.4 сая, орон нутгийн төсөвт байгууллагуудын өглөг 81.5 сая төгрөгөөр нэмэгдэхээр байна. Түлш халаалтын өглөг оны эхнээс 1,252.2 сая төгрөгөөр өсөж байгаа нь нийт өглөгийн 81.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт №8 Төсөвт байгууллагуудын өглөгийн нэр төрлөөрх судалгаа

/сая төгрөгөөр/

Төсвийн захирагч	Эхний үлдэгдэл /2021 оны жилийн эцсийн байдлаар/	Эцсийн үлдэгдэл /2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр /	Цалин хөлстэй холбоотой	Үүнээс:	
				Түлш халаалт	Бусад /гэрэл цахилгаан, ЦБУ, Урсгал засвар, Байрны түрээс гм/
ЕБС-ийн сургуулиудын дүн	545.6	1,440.8	32.10	1,344.20	64.50
Хүүхдийн цэцэрлэгүүдийн дүн	33.7	281.0	30.10	184.00	66.90
Соёлын төвүүдийн дүн	3.3	82.5	0.10	80.90	1.50
ЭМТ-үүдийн дүн	290.8	75.7	8.40	37.20	30.10
ТЗШ-ийн байгууллагуудын дүн	873.44	1,880.00	70.70	1,646.30	163.00
ИТХ-ын дүн	16.70	11.50	11.50		
ЗДТГ-ын дүн	73.50	168.10	105.20	38.90	24.00
Сумын ИТХ, ЗДТГ-уудын дүн	90.20	179.60	116.70	38.90	24.00
Орон нутгийн төсөвт байгууллагуудын дүн	260.50	342.00	5.40	279.30	57.30
НИЙТ ДҮН	1,224.1	2,401.6	192.8	1,964.5	244.3

Эх сурвалж: 2021 оны жилийн эцсийн өглөгийн судалгаа, төсөвт байгууллагуудаас авсан өглөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн судалгаа

2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр гарч буй өглөгийн 1,964.5 сая төгрөг нь түлш халаалтын зардлын өглөг байна. Үүнд: ЕБС-иуд 1,344.2 сая, Хүүхдийн цэцэрлэгүүд 184.0 сая, Соёлын төвүүд 80.9 сая, сумын ЭМТ-үүд 37.2 сая, сумын ЗДТГ-ууд 38.9 сая, аймгийн ХДТ 141.6 сая, БТСГ 96.1 сая, Музей 23.1 сая, Асрамжийн газар 5.1 сая, ОНРТ 3.0 сая, Номын сан 3.4 сая, БОАЖГ 2.0 сая, ХТА 39.9 сая, Ахмадын сан 5.0 сая төгрөгийн халаалтын өглөгтэй байна.

Түлш халаалтын зардлын өглөг их хэмжээгээр нэмэгдэхэд нүүрсний үнийн өсөлт, гэрээгээр гүйцэтгэгч зарим компаниуд өмнөх онуудын халаалтын зардлын зөрүүг шүүхээр тогтоолгон нөхөн төлүүлж байгаа нь нөлөөлж байгаа боловч халаалтын зардлын төсвийн хуваарилалт үндэслэлгүй хийгдэж байгаа нь нөлөөлсөн байна.

Цалин хөлстэй холбоотой өглөгийн 70.7 сая нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 2022 оны 1-4 дүгээр саруудад ТҮ-1-3 ажилчдын цалинг орон нутгийн төсвөөс олгох үед зөвхөн гарт олгох цалин олгосонтой холбоотой үүссэн НДШ, ХХОАТ-ын өглөг, 116.7 сая нь сумын ИТХ, ЗДТГ-уудын өмнөх онд дутуу батлагдсан цалингийн НДШ, ХХОАТ-ын он дамжсан өглөг, 5.4 сая нь орон нутгийн төсөвт байгууллагуудын гэрэл цахилгаан, тээвэр шатахуун, бусад бараа материалын зардлын өглөг байна.

Бусад зардлын тооцооны өглөгийн 163.0 сая нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, байрны түрээсийн зардлын, 24 сая нь сумын ЗДТГ-уудын шатахуун, бусад бараа үйлчилгээний зардлын өглөг, 57.3 сая төгрөгийн өглөг нь орон нутгийн байгууллагуудын гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, тээвэр шатахуун, бусад бараа үйлчилгээний зардлын тооцоогоор үүсэн өглөг байна.

Төсөвт байгууллагуудын өр төлбөрийн байдалд хийсэн тооцоо судалгаанаас үзэхэд он дамжсан өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, шинээр өглөг үүсгэж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийн зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 дахь хэсэгт “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн

төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дүгнэлт

1. Төсөвт байгууллагуудын он дамжсан авлагыг бууруулж ажилласан байна.
2. Он дамжсан өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, өр төлбөр нэмэгдэх эрсдэл үүссэн байна.

Санал зөвлөмж:

1. Төсөвт байгууллагуудын он дамжсан өр төлбөрийг 2023 оны төсөвт тусгаж, барагдуулах арга хэмжээ авах, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГЫГ ХАНГАХГҮЙ БАЙНА

3.1. Аймгийн 2022 оны Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар:

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийн талаар:

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2022 онд аймгийн ОНХС-д 6,989.6 сая төгрөгийн төсөв хуваарилж Сангийн яамнаас хянаж ирүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор ОНХС-ийн төсвийг 6,584.8 сая төгрөгөөр баталжээ. Үүнээс аймгийн ОНХС-д 3,039.1 сая төгрөг, сумдын ОНХС-д 3,545.7 сая төгрөг, ОНХС-гийн суурь зарлагад 383.3 сая төгрөг, Хот тохижуулах албаны үйл ажиллагаанд 21.5 сая төгрөг хуваарилсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний нийт төсөвт өртөг нь 6,589.5 сая төгрөг, тайлант онд санхүүжүүлэх дүн 3,039.2 сая төгрөг байна. Үүнээс шилжих хөрөнгө оруулалт 911.1 сая төгрөг, шинээр хэрэгжих төсөл арга хэмжээ 2,128.0 сая төгрөг байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг анх баталснаас хойш 2022 онд 4 удаа өөрчлөлт оруулж тодотгож баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор хөрөнгө оруулалтын нийт дүнд өөрчлөлт оруулаагүй, төсөл арга хэмжээний тоог анх баталснаас 17-гоор нэмэгдүүлж, 121 төсөл арга хэмжээ болгон өөрчилж, төсөл арга хэмжээний нийт төсөвт өртгийг 350.0 сая төгрөгөөр бууруулж 6,239.5 сая төгрөгөөр баталж, тайлант онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 93 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний тоог 138 болгон өөрчилж, тайлант онд санхүүжих дүнг анх баталснаас 288.0 сая төгрөгөөр бууруулж 2,751.4 сая төгрөгөөр баталсан байна. Төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 6,025.4 сая төгрөгөөр тогтоож, өмнөхөөс 214.1 сая төгрөгөөр бууруулжээ.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 99 дугаар тогтоолоор төсөл арга хэмжээний тоог 3-аар нэмэгдүүлж 141 болгон өөрчилж, нийт төсөвт өртгийг урьд тодотгосноос 564.0 сая төгрөгөөр бууруулан 5,461.4 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 120 тогтоолоор төсөл арга хэмжээний тоог 2-оор бууруулан 139 болгож, төсөвт өртгийг 29.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 5,490.4 сая төгрөгөөр баталсан.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 93 дугаар тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх их засварын 18 төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан байна.

Дээрх байдлаас дүгнэлт хийж үзэхэд Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг анхнаасаа үндэслэл муутай төлөвлөсөн байна гэж үзэх үндэстэй байна.

Иймд Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 оны хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг бодит тооцоо судалгаанд үндэслэн үр өгөөжтэй хөрөнгө оруулалтад төлөвлөх, төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулахад анхаарах шаардлагатай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Замын сангийн хөрөнгө оруулалтын талаар:

Аймгийн ИТХ-ын 2021 оны 51 дүгээр тогтоолоор Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсвийг 900.8 сая төгрөгөөр, Замын сангийн төсвийг 639.1 сая төгрөгөөр баталсан.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 900.8 сая төгрөгийн их засвар болон Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 639.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг тогтоолын хавсралтаар батлаагүй, нийт дүнгээр баталжээ.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/416 дугаар захирамжийн хавсралтаар Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан байна.

Аймгийн 2022 оны Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн явцыг судалж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 2,751.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 139 төсөл арга хэмжээний 1,636.1 сая төгрөгийн ажлыг санхүүжүүлсэн ба ажлын гүйцэтгэл 59.5 хувьтай байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 900.8 сая төгрөгийн их засварын 17 төсөл арга хэмжээнээс 698.7 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээ хийгдэж, 458.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, ажлын гүйцэтгэл 65.6 хувьтай байна.
- Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих 639.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 төсөл арга хэмжээнээс 34 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээ хийгдэж, 493.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, ажлын гүйцэтгэл 77.2 хувьтай байна.

3.2. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт хуульд заасан шаардлагыг хангахгүй байна

3.2.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг төсөл арга хэмжээ тус бүрээр төлөвлөөгүй байгаа нь хуульд заасан шаардлагыг хангахгүй байна

Аймгийн 2023 оны төсвийн төсөлд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх их засварт нийтдээ 1,351.2 сая төгрөг, Замын сангийн хөрөнгө оруулалтад нийтдээ 1,153.7 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн төсөлд дээрх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний дэлгэрэнгүй жагсаалтыг төсөл арга хэмжээ бүрээр бэлтгэж ирүүлээгүй нийт дүнгээр батлуулахаар төлөвлөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, 33 дугаар зүйлийн 33.2.6-д “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/” гэсэн заалт,

мөн Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1-д “Төслийн төлөвлөх харилцааг энэ журмын 1.2.2-т заасан журам болон аргачлалд зааснаар зохицуулна”, 3.1.2-т “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төслүүд нь төсвийн хөрөнгө оруулалтаар зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай нь холбогдох нотлох баримтаар тогтоогдсон төсөл байх бөгөөд энэ журамд зааснаар төлөвлөнө” гэсэнтэй нийцэхгүй байна.

Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ”, 25.2.1-д “авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар”, Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Автозамын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 2.1-д “..... нийслэл, орон нутгийн авто замын сан нь Авто замын тухай хуулийн 25.2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ” гэж заасан.

Орон нутгийн 2022 оны татварын орлогын төлөвлөгөөнд авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвараас нийтдээ 500.0 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс Татварын хэлтсээс гаргаж ирүүлсэн 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 520.0 сая төгрөгийн орлого орох төлөвтэй байна.

Төсвийн төсөлд Авто болон өөрөө явагч хэрэгслийн татвараас 2023 онд нийтдээ 550.0 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн боловч Замын сангийн хөрөнгө оруулалтад 1,153.7 сая төгрөг зарцуулахаар тусгасан нь татвараас орох орлогоос 2 дахин их дүнтэй байгаа нь бүрэн хэрэгжих эсэх нь эргэлзээтэй, төлөвлөлт үндэслэлгүй байгааг харуулж байна.

Иймд Замын сангийн хөрөнгө оруулалтын дүнг 600.0 сая төгрөгөөр бууруулж төлөвлөх саналтай байна.

3.2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүд нь хуульд заасан шаардлага хангасан эсэх талаар дүгнэлт гаргах боломжгүй байна.

Аймгийн ОНХС-д 2023 онд нийтдээ 8,028.8 сая төгрөгийн төсөв хуваарилж Сангийн яамнаас хянаж ирүүлжээ. Үүнээс аймгийн ОНХ-д 3,926.5 сая төгрөгийг, сумдын ОНХС-д 4,102.2 сая төгрөгийг хуваарилсан байна.

Үүнд шилжих хөрөнгө оруулалтад 850.0 сая төгрөгийг, шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтад барилга 389.0 сая төгрөгийг, зам засвар, гүүрийн ажил 160.0 сая төгрөгийг, гэрэлтүүлэг 145.0 сая төгрөг, цахилгаанд холбох ажил 183.5 сая төгрөгийг, худаг гаргах ажилд 35.0 сая төгрөгийг, тоног төхөөрөмж худалдан авах арга хэмжээнд 604.8 сая төгрөг, бусад төсөл арга хэмжээнд 1599.2 сая төгрөгийг тус тус хуваарилжээ.

- Аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад Өлгий сумын 2 дугаар багт цэвэр усны шугам татах, Ногооннуур, Цэнгэл, Өлгий сумд гэрэлтүүлэг тавих, Өлгий сумын захын айлуудад цахилгаан шугам татах, Эзэнгүй хогийг цэвэрлэх 458.5 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээний зураг төсөв нь хийгдээгүй, мөн 401.0 сая төгрөгийн 11 төрлийн тоног төхөөрөмж, эд хогшил бэлтгэх ажлын техникийн тодорхойлолт, үнийн судалгаа хийгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.3-д заасан "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

- Алтанцөгц сумын Хүн эмнэлгийн хуучин барилгыг цэцэрлэгийн зориулалтаар өөрчлөх их засварын ажлыг 100.0 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч энэ нь 2022 оны их засварын хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтад орсон, 95.0 сая төгрөгөөр гэрээ хийгдэж хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээ байна.

- Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах "Бүх сумын хогийн отвалыг цэгцлэх, дарж булах" төсөл арга хэмжээнд нийтдээ 120.0 сая төгрөг төлөвлөсөн байна.

- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үндсэн багш, арга зүйч, сургалтын менежерийн компьютерийн хангамж төсөл арга хэмжээний нийт 4,427.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч энэ нь хэдэн жил үргэлжлэх, ямар хугацаанд хэрэгжиж дуусах нь тодорхой бус байна. Үүнд тайлант онд 120.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөжээ.

- Скайтелын модемын эрх нээлгэх, нэгж авахад 5.1 сая төгрөг, Ховд голын эрэг дэх нүхэн жорлонгуудыг булахад 10.0 сая төгрөг тусгасан нь хөрөнгө оруулалт бус урсгал зардлын шинжтэй зүйл байна.

Бид Аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 1-01/1608 дугаар албан бичгээр аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг тус аудитын газарт 11 дүгээр сарын 28-ны өдөр ирүүлсэний дагуу ОНХС-гийн төсвийн төсөлд дүгнэлт саналаа боловсрууллаа.

Харин Аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 2-01/1625 албан бичгээр аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад дахин өөрчлөлт оруулж ирүүлжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт "Аймаг, нийслэлийн жилийн төсвийг дараах цаглабрын дагуу боловсруулж, батална", 8.5.1-д "аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх" гэж заасныг зөрчиж байгаа бөгөөд өөрчлөлт оруулж шинэчлэн ирүүлсэн төсөл арга хэмжээнүүд нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-д нийцүүлж төлөвлөсөн эсэхэд цаг хугацааны хувьд дүгнэлт гаргахад боломжгүй байсан болно.

Дүгнэлт:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад 4 төсөл арга хэмжээнд 355.1 сая төгрөгийг хэрэгжих боломжгүй, зардлын шинжтэй төсөл арга хэмжээг төлөвлөсөн

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад зураг төсөв нь батлагдаагүй 458.5 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ, 401.0 сая төгрөгийн техникийн тодорхойлолт, үнийн судалгаа хийгдээгүй 11 ажлыг тусгасан.

3. Орон нутгийн хөрөнгө оруулалтын их засварын төсвийг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ тус бүрээр төлөвлөөгүй, хуульд заасан шаардлагыг хангаагүй байна.

4. Замын сангийн хөрөнгө оруулалтын төсвийг эх үүсвэрээс үндэслэлгүй илүү төлөвлөсөн байна.

5. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр төсөл арга хэмжээний жагсаалтад өөрчлөлт оруулж шинэчлэн ирүүлсэн жагсаалтад санал дүгнэлт өгөх боломжгүй байна.

Санал зөвлөмж:

1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7-д "Аймаг, нийслэлийн түвшинд ОНХС-ийн төлөвлөлт" гэсэн заалтад нийцүүлж зохион байгуулж, аймгийн ИТХ-д хэлэлцүүлэх төсвийн төслийг жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аймаг, нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлж ажиллах.

2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх их засварын жагсаалтыг хуульд заасан шаардлагад нийцүүлэн төсөл арга хэмжээ тус бүрээр төлөвлөж батлуулах.

3. Аймгийн 2023 оны ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг хуулийн хугацаанд ирүүлэх.

4. Замын сангийн хөрөнгө оруулалтын төсвийг замын сангийн 2023 оны эх үүсвэртэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөх.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 1,504.0 сая төгрөгөөр тасрах төлөвтэй байна.

2. Аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг өндөр төлөвлөсөн нь биелэгдэхгүй байх эрсдэлтэй байна.

3. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын өөрийн орлогоос 2023 онд 345.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн нь бүрэн төлөгдөх боломжгүй байна.

4. Сумуудын орон нутгийн суурь орлогыг нэмэгдүүлэх боломжуудыг бүрэн тооцоолоогүй байна.

5. Аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн суурь зарлагыг Сангийн яамнаас хянаж ирүүлсэн дүнгээс 2716.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

6. Цалингийн зардлыг 1,153.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

7. Он дамжсан өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, өр төлбөр нэмэгдэх эрсдэл үүссэн байна.

8. Халаалтын төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр оны эцэст 1,964.5 сая төгрөгийн өглөгтэй гарахаар байна.

9. Орон нутгийн хөрөнгө оруулалтын их засварын төсвийг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ тус бүрээр төлөвлөөгүй, хуульд заасан шаардлагыг хангаагүй байна.

10. Замын сангийн хөрөнгө оруулалтын төсвийг эх үүсвэрээс үндэслэлгүй илүү төлөвлөсөн байна.

11. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр төсөл арга хэмжээний жагсаалтад өөрчлөлт оруулж шинэчлэн хүргэсэн жагсаалтад дүгнэлт өгөх боломжгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

1. Биелэгдэх боломжгүй татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг дахин хянаж, үндэслэлтэй төлөвлөх;
2. Аймгийн ИТХ-аас баталсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллах;
3. Орон нутгийн төсөвт байгууллагуудын орон тооны нягтралыг сайжруулж, шаардлагагүй орон тоог хасах замаар цалингийн зардлыг хэмнэх;
4. Төсөвт байгууллагуудын он дамжсан өр төлбөрийг 2023 оны төсвийн төслийн төлөвлөгөөнд тусгаж, барагдуулах арга хэмжээ авах, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах;
5. Толбо сумын сургуульд 54.0 сая, Цэнгэл сумын Тува бага сургуульд 37.3 сая, Цагааннуур тосгоны дунд сургуульд 36.0 сая, нийт 127.3 төгрөгийн халаалтын төсвийг үндэслэлгүй нэмэгдүүлснийг өртэй байгууллагуудын халаалтын зардалд шилжүүлэх;
6. Төсөвт байгууллагуудын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд тавих хяналтыг сайжруулж, батлагдсан төсөвт зардлыг хэмнэлттэй зарцуулах;
7. Нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглаж зардлыг хэмнэх;
8. “СУАТ”-ХХК-ы урт хугацаат зээлийн төлбөр болон хүүгийн төлбөрт орон нутгийн төсвөөс төлсөн зардлыг “СУАТ” ХХК-аар бүрэн төлүүлж орон нутгийн төсөвт оруулах;
9. Аймгийн 2023 оны ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг хуулийн хугацаанд ирүүлэх;
10. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7-д “Аймаг, нийслэлийн түвшинд ОНХС-ийн төлөвлөлт” гэсэн заалтад нийцүүлж зохион байгуулж, аймгийн ИТХ-д хэлэлцүүлэх төсвийн төслийг жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аймаг, нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлж ажиллах;
11. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх их засварын жагсаалтыг хуульд заасан шаардлагад нийцүүлэн төсөл арга хэмжээ тус бүрээр төлөвлөж батлуулах;
12. Замын сангийн хөрөнгө оруулалтын төсвийг замын сангийн 2023 оны эх үүсвэртэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2022 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ